+

**ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХӨА-2024/232/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.26 № 01/168

танай ____________ -ны № ____________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Т.ЭНХБАЯР ТАНАА

## Хараат бус аудиторын дүгнэлт

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас гаргасан ерөнхий боловсролын сургуулийн математикийн жишиг лабораторийн дагуу бичигдсэн "Оюуны үндарга математикийн кабинет"-ийн төслийг шалгаруулж, нөхөн хангалтын зардлаар 118,690.4 өртөгтэй кабинетыг ашиглалтад оруулж багш, сурагчдын сэтгэл ханамж, сурч боловсрох орчин нөхцөлийг сайжруулсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитаар нийт 9,842.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 6,916.0 мянган төгрөгийн алдааг залруулж, батлагдсан төсвийг хөтөлбөр арга хэмжээний зориулалтаар зарцуулаагүй 2,000.0 мянган төгрөгийг төлбөрийн акт тогтоож, 926,0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

### Бусад асуудлын хэсэг

Тус сургуулийн захирал нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Жаргалант сумын Засаг даргаар батлуулж, түүнийг 87.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

Багш бүрийг компьютержуулах зорилгын хүрээнд БШУЯ-аас тус сургуульд 51 ширхэг зөөврийн компьютер хүлээлгэн өгсөн боловч анхан шатны баримт ирээгүй, орлогод авах үнэ тодорхойгүйгээс шалтгаалан бүртгэлд тусгаагүй байгааг дараагийн аудитаар анхаарах асуудалд тусгасан.

6724040215

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **311,353,545.35** | **600,543,688.51** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **46,524,106.40** | **321,002,386.67** |
| **Т31200** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | **46,524,106.40** | **321,002,386.67** |
| **31210** | **Төгрөг** | **46,524,106.40** | **321,002,386.67** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 46,524,106.40 | 321,002,386.67 |
| **33** | **АВЛАГА** | **4,400,000.00** | **128,978.87** |
| **33500** | **Бусад авлага** | **4,400,000.00** | **128,978.87** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | | 128,978.87 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 4,400,000.00 | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **260,429,438.95** | **279,412,322.97** |
| **35100** | **Түүхий эд материал** | **2,052,740.00** | **2,052,740.00** |
| 35130 | Эм боох материал | 2,052,740.00 | 2,052,740.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **258,376,698.95** | **277,359,582.97** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 13,029,105.00 | 17,104,212.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 17,120,109.81 | 15,252,600.81 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 825,000.46 | 3,075,000.46 |
| 35450 | Барилгын засварын материал | 13,829,357.86 | 22,815,738.86 |
| 35460 | Хүнсний материал | 70,178,632.20 | 66,535,463.20 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 143,394,493.62 | 152,576,567.64 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,468,625,875.32** | **2,381,509,303.06** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,468,625,875.32** | **2,381,509,303.06** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **2,403,312,503.69** | **2,309,279,931.43** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,428,421,603.00 | 2,426,549,194.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -392,077,395.01 | -486,126,738.21 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -2,500,000.00 | -2,500,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 520,875,780.48 | 566,404,255.48 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -271,682,634.92 | -315,172,581.71 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 153,708,997.52 | 186,076,852.62 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -94,310,553.02 | -105,312,262.37 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,973,359.00 | 4,917,484.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -4,917,484.00 | -4,917,484.00 |
| 39217 | Ном | 58,320,830.64 | 36,861,211.62 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **65,313,371.63** | **72,229,371.63** |
| 39301 | Программ хангамж | 11,555,745.00 | 11,555,745.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -5,826,373.37 | -5,826,373.37 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 59,584,000.00 | 66,500,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,779,979,420.67** | **2,982,052,991.57** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,779,979,420.67** | **2,982,052,991.57** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,779,979,420.67** | **2,982,052,991.57** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 1,231,441,861.00 | 1,231,441,861.00 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 1,231,441,861.00 | 1,231,441,861.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **693,483,420.22** | **897,586,700.12** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 779,722,113.02 | 695,513,129.22 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -86,238,692.80 | 202,073,570.90 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 855,054,139.45 | 853,024,430.45 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,779,979,420.67** | **2,982,052,991.57** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,459,100,671.30** | **3,007,607,180.12** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,459,100,671.30** | **3,007,607,180.13** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **111,557,171.30** | **62,528,780.12** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | | **6,192,200.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,766,100.00 | 6,192,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 106,791,071.30 | 56,336,580.12 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа | | |

| | | | |
|---|---|---|---|
| | материал | | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,347,543,500.00** | **2,945,078,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **2,015,557,800.00** | **2,691,898,500.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,015,557,800.00 | 2,691,898,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **331,985,700.00** | **253,179,900.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 331,985,700.00 | 253,179,900.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,412,879,211.22** | **2,805,352,934.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,412,879,211.22** | **2,803,195,494.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,269,746,601.11** | **2,672,648,081.85** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,490,764,255.63** | **1,777,804,452.71** |
| 210101 | Үндсэн цалин | 1,118,004,802.22 | 1,225,090,330.28 |
| 210102 | Нэмэгдэл | 340,432,105.93 | 477,145,377.45 |
| 210104 | Урамшуулал | 32,327,347.48 | 75,568,744.98 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **183,936,646.49** | **228,502,328.69** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 124,950,471.84 | 157,451,015.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,652,646.66 | 17,709,424.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,098,005.74 | 14,607,594.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,930,529.33 | 3,509,939.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 29,304,992.92 | 35,224,354.36 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **250,265,875.89** | **215,900,687.35** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,795,515.89 | 21,698,611.35 |
| 210302 | Түлш, халаалт | 226,837,536.00 | 185,534,976.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,632,824.00 | 8,667,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **36,442,388.00** | **61,665,298.02** |
| 210401 | Бичиг хэрэг | 15,456,488.00 | 9,988,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,566,900.00 | 13,952,687.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 21,459,619.02 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,419,000.00 | 16,264,992.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **89,391,142.60** | **130,766,279.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,376,860.00 | 550,450.00 |
| 210502 | Хоол, хүнс | 88,014,282.60 | 130,215,829.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **11,624,750.00** | **22,942,600.00** |
| 210604 | Урсгал засвар | 11,624,750.00 | 22,942,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **10,235,200.00** | **20,696,299.46** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,471,900.00 | 6,190,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,763,300.00 | 14,505,799.46 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **197,086,342.50** | **214,370,136.62** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,582,650.27 | 23,108,150.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 12,139,580.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 175,503,692.23 | 179,122,406.62 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **143,132,610.11** | **130,547,412.65** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **130,529,200.00** | **130,491,000.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 130,529,200.00 | 130,491,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **12,603,410.11** | **56,412.65** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,603,410.11 | 56,412.65 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **2,157,440.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | | **2,157,440.00** |
| 223001 | Хаагдсан данс | | 2,157,440.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **46,221,460.08** | **202,254,245.62** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **156,644,154.40** | **180,674.72** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 156,644,154.40 | 180,674.72 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | **-86,238,692.80** | **202,073,570.90** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,348,235,400.00** | **2,951,270,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **691,900.00** | **6,192,200.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **691,900.00** | **6,192,200.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **691,900.00** | **6,192,200.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 621,900.00 | 6,192,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 70,000.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,347,543,500.00** | **2,945,078,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **2,015,557,800.00** | **2,691,898,500.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,015,557,800.00 | 2,691,898,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **331,985,700.00** | **253,179,900.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 331,985,700.00 | 253,179,900.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,231,958,293.60** | **2,613,722,319.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,231,958,293.60** | **2,613,722,319.73** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,088,825,683.49** | **2,483,174,907.08** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,462,920,101.55** | **1,777,933,431.58** |
| 210101 | Үндсэн цалин | 1,087,741,521.67 | 1,225,219,309.15 |
| 210102 | Нэмэгдэл | 341,476,294.00 | 477,145,377.45 |
| 210104 | Урамшуулал | 33,702,285.88 | 75,568,744.98 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **183,522,599.05** | **228,502,328.69** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 124,912,412.41 | 157,451,015.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,652,646.66 | 17,709,424.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,722,017.33 | 14,607,594.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,930,529.33 | 3,509,939.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 29,304,993.32 | 35,224,354.36 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **245,962,399.89** | **219,623,487.35** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,795,515.89 | 21,698,611.35 |
| 210302 | Түлш, халаалт | 222,534,060.00 | 187,784,976.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,632,824.00 | 10,139,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **111,801,083.00** | **124,412,660.00** |
| 210502 | Хоол, хүнс | 111,801,083.00 | 124,412,660.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **11,835,800.00** | **33,500,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 11,835,800.00 | 33,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **16,861,000.00** | **20,723,299.46** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,471,900.00 | 6,190,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 13,389,100.00 | 14,532,799.46 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **55,922,700.00** | **78,479,700.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,839,100.00 | 56,680,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 20,083,600.00 | 21,799,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **143,132,610.11** | **130,547,412.65** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **130,529,200.00** | **130,491,000.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 130,529,200.00 | 130,491,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **12,603,410.11** | **56,412.65** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,603,410.11 | 56,412.65 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **116,277,106.40** | **337,548,280.27** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **69,753,000.00** | **63,070,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **69,753,000.00** | **63,070,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **69,753,000.00** | **63,070,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 69,753,000.00 | 63,070,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-69,753,000.00** | **-63,070,000.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **46,524,106.40** | **274,478,280.27** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 46,524,106.40 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 46,524,106.40 | 321,002,386.67 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,231,441,861.00** | **1,318,464,644.45** | **779,722,113.02** | **3,329,628,618.47** |
| Дахин илэрхийлсэн | 1,231,441,861.00 | 1,318,464,644.45 | 779,722,113.02 | 3,329,628,618.47 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| үлдэгдэл | | | | |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | -463,410,505.00 | | -463,410,505.00 |
| Тайлант үеийн үр дүн | | | -86,238,692.80 | -86,238,692.80 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,231,441,861.00** | **855,054,139.45** | **693,483,420.22** | **2,779,979,420.67** |
| **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,231,441,861.00** | **855,054,139.45** | **693,483,420.22** | **2,779,979,420.67** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 2,029,709.00 | 2,029,709.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,231,441,861.00 | 855,054,139.45 | 695,513,129.22 | 2,782,009,129.67 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | -2,029,709.00 | | -2,029,709.00 |
| Тайлант үеийн үр дүн | | | 202,073,570.90 | 202,073,570.90 |
| **2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **1,231,441,861.00** | **853,024,430.45** | **897,586,700.12** | **2,982,052,991.57** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | гүйцэтгэлийн | Хувь | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,745,115,000.00** | **2,423,612,419.73** | **88.29** | **321,502,580.27** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,745,115,000.00** | **2,423,612,419.73** | **88.29** | **321,502,580.27** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,587,365,900.00** | **2,293,121,419.73** | **88.63** | **294,244,480.27** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,034,536,400.00** | **1,777,933,431.58** | **87.39** | **256,602,968.42** |
| 210101 | Үндсэн цалин | 1,403,718,500.00 | 1,225,219,309.15 | 87.28 | 178,499,190.85 |
| 210102 | Нэмэгдэл | 544,580,500.00 | 477,145,377.45 | 87.62 | 67,435,122.55 |
| 210104 | Урамшуулал | 86,237,400.00 | 75,568,744.98 | 87.63 | 10,668,655.02 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **254,317,000.00** | **228,502,328.69** | **89.85** | **25,814,671.31** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 172,935,600.00 | 157,451,015.36 | 91.05 | 15,484,584.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 20,345,300.00 | 17,709,424.11 | 87.04 | 2,635,875.89 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 16,276,300.00 | 14,607,594.93 | 89.75 | 1,668,705.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,069,100.00 | 3,509,939.93 | 86.26 | 559,160.07 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 40,690,700.00 | 35,224,354.36 | 86.57 | 5,466,345.64 |
| **2105** | **Нормативт зардал** | **135,737,800.00** | **124,412,660.00** | **91.66** | **11,325,140.00** |
| 210502 | Хоол, хүнс | 135,737,800.00 | 124,412,660.00 | 91.66 | 11,325,140.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **20,725,000.00** | **20,723,299.46** | **99.99** | **1,700.54** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,192,200.00 | 6,190,500.00 | 99.97 | 1,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 14,532,800.00 | 14,532,799.46 | 100.00 | 0.54 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **142,049,700.00** | **141,549,700.00** | **99.65** | **500,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 120,250,500.00 | 119,750,500.00 | 99.58 | 500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 21,799,200.00 | 21,799,200.00 | 100.00 | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **157,749,100.00** | **130,491,000.00** | **82.72** | **27,258,100.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **157,749,100.00** | **130,491,000.00** | **82.72** | **27,258,100.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 157,749,100.00 | 130,491,000.00 | 82.72 | 27,258,100.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,745,115,000.00** | **2,698,090,700.00** | **98.29** | **47,024,300.00** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,691,898,500.00** | **2,691,898,500.00** | **100.00** | |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,691,898,500.00 | 2,691,898,500.00 | 100.00 | |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **53,216,500.00** | **6,192,200.00** | **11.64** | **47,024,300.00** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,192,200.00 | 6,192,200.00 | 100.00 | |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 500,000.00 | | | 500,000.00 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 46,524,300.00 | | | 46,524,300.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 46,524,106.40 | | -46,524,106.40 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 321,002,386.67 | | -321,002,386.67 |

## 2.6 Орон нутгийн төсвийн гүйцэтгэл

төгрөг

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **253,179,900.00** | **253,123,487.35** | **99.98** | **56,412.65** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **253,179,900.00** | **253,123,487.35** | **99.98** | **56,412.65** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **253,179,900.00** | **253,123,487.35** | **99.98** | **56,412.65** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **219,679,900.00** | **219,623,487.35** | **99.97** | **56,412.65** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,000,000.00 | 21,698,611.35 | **144.66** | **-6,698,611.35** |
| 210302 | Түлш, халаалт | 194,679,900.00 | 187,784,976.00 | **96.46** | **6,894,924.00** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,000,000.00 | 10,139,900.00 | **101.40** | **-139,900.00** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **33,500,000.00** | **33,500,000.00** | **100.00** | |
| 210604 | Урсгал засвар | 33,500,000.00 | 33,500,000.00 | **100.00** | |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **253,179,900.00** | **253,236,312.65** | **100.02** | **-56,412.65** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **253,179,900.00** | **253,236,312.65** | **100.02** | **-56,412.65** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 253,179,900.00 | 253,236,312.65 | **100.02** | **-56,412.65** |

# 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,919,096.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 2,000.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,919,096.3 мянган төгрөгийн шилэн дансны зөрчилд албан шаардлага, 926.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 2 зөвлөмжийг Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал, нягтлан бодогч нарт хүргүүлж байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,926.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 35,293.1 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

## 3.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 6,916.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 6,916.0 мянган төгрөгийн алдааг залруулав.

*Залруулсан алдаа:*

- Байгууллагын эзэмшил газрын захирамж, гэрээ, гэрчилгээ, кадастрын зураг зэрэг бичиг баримтын зөрчлийг тулган шалгахад газрын хэмжээнд орсон өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй орхигдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал бүртгэнэ гэсэн заалтад нийцэхгүй, **“үнэлгээ ба хуваарилалт”** батламж мэдэгдлийг хангахгүй байх тул дээрх стандарт, хууль, журамд нийцүүлэн бүртгэж залруулав.

### 3.2 Төлбөрийн акт

1. Багшийн тасралтгүй үйл ажиллагааг дэмжих сургалттай холбоотой асуудал.

*Илрүүлэлт:*

Багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргахдаа мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах чиг үүрэгтэй, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн Э. Ундрах, Авьяас ерөнхий боловсролын сургуулийн захирал Г. Анхтуяа нартай гэрээ байгуулан, төлбөртэй сургалт хийлгэж 2,000,0 мянган төгрөгийн төлбөр төлсөн байна. Энэ нь Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.5-д “Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс харьяа нутаг дэвсгэртээ дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах”, мөн хуулийн "33 дугаар зүйлийн 33.3. 4 Боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: суралцагчийн хөгжил, төлөвшлийг дэмжих, сурлагын амжилт чанарыг сайжруулахын тулд багшид шаардлагатай мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтад нийцэхгүй, **“нийцсэн бөгөөд зохистой байх”** батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Төлбөрийн акт тогтоов.*

### 3.3 Албан шаардлага

*Илрүүлэлт:*

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь, бүрэн байршуулах өмнөх оны аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,532,750.4 мянган төгрөгийн 50 мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 383,420.3 мянган төгрөгийн 25 мэдээллийг байршуулаагүй нь “Шилэн дансны тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” заалт, 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” заалт болон “ нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байх тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

*Албан шаардлага хүргүүлэв*

### 3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Сургуулийн цахим хэрэглээний зардлаас 5 ажилтанд дата багц олгосон нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” , БШУС-ын 2019 оны А/170 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-тай нийцэхгүй, **“үнэлгээ ба хуваарилалт”** батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Төсвийг батлагдсан зориулалт, арга хэмжээний дагуу, холбогдох хууль, журам, заавварт нийцүүлэн зарцуулж байх.

**2. Анхан шатны бүртгэлтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын хүүхдийн хоол, хүнсний зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримт руу хөөн шалгахад гал тогооны хоолны захиалгын цэс дэх хүүхдийн тоо, дотуур байрын багшийн ирцийн бүртгэлийн тоотой зөрүүтэй, байрын багш өдөр тутмын бүртгэлийг хүүхэд бүрээр бүртгээгүй ирцийн тоог бөөн дүнгээр хоолны захиалгын хуудсанд бичсэнээр 176.0 мянган төгрөгийн хоол, хүнсний материалыг илүү захиалсан зөрчил илэрч байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.1”нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах”, “13.3.Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 14.2-т зааснаас бусад өөрийн онцлогт тохирсон дотооддоо мөрдөх анхан шатны баримт, маягтыг дүрэмдээ заасан эрх бүхий удирдах байгууллагаар батлуулан мөрдөж болно” гэсэн заалтуудад нийцэхгүй **“үнэлгээ ба хуваарилалт”** батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

БШУЯ-аас баталсан дотуур байрын хүүхдийн өдөр тутмын ирцийн бүртгэлийн дэвтрийг бүрэн хөтлүүлж гал тогооны хоолны захиалгын цэс дэх хүүхдийн тоотой тулган шалгаж анхан шатны бүртгэлийг бүрэн хөтөлж хэвших.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Байгууллагын эзэмшил газрын захирамж, гэрээ, гэрчилгээ, кадастрын зураг зэрэг бичиг баримтын зөрчлийг тулган шалгахад газрын хэмжээнд орсон өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй орхигдуулсан | 1 | 6,916.0 | | | 1 | 6,916.0 | 1 | 6,916.0 | | | | |
| **Дүн** | **1** | **6,916.0** | | | **1** | **6,916.0** | **1** | **6,916.0** | **0** | **0** | **0** | **0** |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Багшийн хөгжлийн зардлаас сургалтын төлбөр гаргасан | 7 | 2,926.0 | 2 | 2,000.0 | 0 | 0 | 5 | 926,0 | | | 0 | 0 |
| Дүн | 7 | 2,926.0 | 2 | | | | 5 | 926.0 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь, бүрэн байршуулах өмнөх оны аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,532,750.4 мянган төгрөгийн 50 мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 383,420.3 мянган төгрөгийн 25 мэдээллийг байршуулаагүй | 1 | 2,916,170.3 | 1 | 2,916,170.3 | | |
| Дүн | 1 | 2,916,170.3 | 1 | 2,916,170.3 | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| Дүн | | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **2,916,170.3** | **1** | **2,916,170.3** | | |

## 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | Аудитад хамрагдах | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 09 сарын 26 өдөр № 33/12270439/ХӨА-2024/232/НА-СТА-ТШЗ Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

**Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:**

Багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргахдаа мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах чиг үүрэгтэй, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн Э. Үндрах, Авьяас сургуулийн захирал Г. Анхтуяа нартай гэрээ байгуулан, төлбөртэй сургалт хийлгэж 2,000,000 /хоёр сая / төгрөгийн төлбөр төлсөн байна.

Энэ нь Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.5-д "Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс харьяа нутаг дэвсгэртээ дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах", 33 дугаар зүйлийн 33.3. 4 Боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ, суралцагчийн хөгжил, төлөвшлийг дэмжих, сурлагын амжилт чанарыг сайжруулахын тулд багшид шаардлагатай мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, "Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах чиг үүрэгтэй албан хаагчид гэрээгээр төлсөн төлбөр 2,000,000 /хоёр сая/ төгрөгийг Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн Э.Үндрах, Авьяас сургуулийн захирал Г.Анхтуяа нараас хавсралтад зааснаар гаргуулж Хөвсгөл аймгийн Төрийн сан дахь 100170000955/Хө.Бусад нэр заагдаагүй орлого/ тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар[1]т нотлох баримтын хамт ирүүлэхийг Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Т.Энхбаяр, нягтлан бодогч Б.Эрдэнэтуяа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

"ИХЭР МӨРӨН АУДИТ"ХХК
ЗАХИРАЛ Б.МЯДАГМАА

[1] Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 давхар, 302 тоот

6724020106

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 09 дугаар сарын 26 -ны өдрийн 33/А0970439/ХӨА-2024/232/ төлбөрийн актын хавсралт ХӨА-СТА-ТШЗ

ТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

| Д/д | Овог нэр | Албан тушаал | Төлбөрийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Э. Ундрах | Боловсрол, шинжлэх ухаан газрын мэргэжилтэн | 1,000,000.0 |
| 2 | Г. Анхтуяа | Авьяас ерөнхий боловсролын сургуулийн захирал | 1,000,000.0 |
| | **Дүн** | | **2,000,000.0** |

oooOooo